



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г Дүрэм батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дүрмийг мөрдөж ажиллахыг орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөл, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Г.Банзрагч/-нд даалгасугай.

ДАРГА

Х.БУЛГАНТУЯА



Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2024-ны 06 дугаар сарын 10. өдрийн
08. дугаар тогтоолын хавсралт

ОРОН ТООНЫ БУС ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫН
ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулах үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөл /цаашид "Хяналтын зөвлөл" гэнэ/-ийн үйл ажиллагаанд энэхүү дүрмийг мөрднө.

1.2. Хяналтын зөвлөл үйл ажиллагаандaa улс төрийн болон бусад ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, шударга ёс, тэгш байдлыг эрхэмлэн, хараат бусаар ажиллах, бодит байдалд нийцсэн хөндлөнгийн дүгнэлт, зөвлөмж гаргах зарчмыг баримталж ажиллана.

1.3. Хяналтын зөвлөл нь албан хэрэгцээнд ашиглах дүгнэлт, зөвлөмж, удирдамжийн хэвлэмэл хуудастай байна.

Хоёр. Хяналтын зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх

2.1. Хяналтын зөвлөл нь төрийн, төрийн бус байгууллага, хөрөнгө оруулалтын мэргэжлийн хороо, даатгуулагчийн төлөөлөл бүхий орон тооны бус 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байна:

2.1.1. төрийн байгууллагыг төлөөлж хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын салбарын хяналтын асуудал хариуцсан нэгж болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас тус бүр нэг хүн;

2.1.2. төрийн бус байгууллагыг төлөөлж нэг хүн;


2.1.3. хөрөнгө оруулалтын мэргэжлийн хороог төлөөлж хоёр хүн;

2.1.4. даатгуулагчийг төлөөлж хоёр хүн.

2.2. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл /цаашид "Үндэсний зөвлөл" гэх/ Хяналтын зөвлөлийн гишүүнийг томилж, чөлөөлнө.

2.3. Төрийн бус байгууллага, хөрөнгө оруулалтын мэргэжлийн хороо, даатгуулагчийн төлөөллийг гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулж, томилох бөгөөд сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үйл ажиллагааг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /цаашид "ажлын алба" гэх/ хариуцна.

2.4. Ажлын алба сонгон шалгаруулалтын тов, үргэлжлэх хугацааг тогтоож, зарыг 14-өөс доошгүй хоногийн өмнө хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал



эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим хуудас болон 5-аас доошгүй хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүртээмжтэй байдлаар олон нийтэд мэдээлнэ.

2.5. Сонгон шалгаруулалтад оролцогсод нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.5.1. Монгол Улсын иргэн байх;

2.5.2. хууль эрх зүй, эдийн засаг, банк санхүүгийн чиглэлээр бакалавраас дээш боловсрол эзэмшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;

2.5.3. хугацаа хэтэрсэн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй байх /бүх төрлийн тэтгэвэр авагч хамаarahгүй/;

2.5.4. нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтантай сүүлийн 2 жилийн хугацаанд хамтран ажиллаагүй, гэрээний дагуу ажил, үйлчилгээ эрхэлж байгаагүй байх;

2.5.5. өмнө удирдаж байсан хуулийн этгээдийг өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас дампууруулаагүй байх;

2.5.6. санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх;

2.5.7. нийгмийн даатгалын салбарт ахлах мэргэжилтэн, удирдах ажилтнаар 10-аас доошгүй жил ажилласан байх;

2.5.8. хувь хүний ёс зүй, нэр хүнд нь зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх;

2.5.9. нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай зөрчилдөхгүй байх;

2.5.10. Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж үүхээр ял шийтгүүлж байгаагүй байх.

2.6. Төрийн бус байгууллагууд, хөрөнгө оруулалтын мэргэжлийн хороо энэ дүрмийн 2.5-д заасан шаардлагыг хангасан 3 хүртэлх тооны төлөөллөө нэр дэвшүүлнэ.

2.7. Даатгуулагчийг төлөөлж, энэ дүрмийн 2.5-д заасан шаардлагыг хангасан иргэн өөрийгөө нэр дэвшүүлнэ.



2.8. Сонгон шалгаруулалтад оролцогчоос дараах нийтлэг баримт бичгийг цаасан болон цахимаар хүлээн авна:

2.8.1. сонгон шалгаруулалтад оролцогчийн асуулга

2.8.2. боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг

2.8.3. зөвлөлийн гишүүнээр ажиллах зорилго, хүсэл эрмэлзэл, хийх ажил, өөрийн мэдлэг, ур чадвараа илэрхийлсэн хүсэлт;

2.8.4. иргэний үнэмлэхийн хуулбар;

2.8.5. цээж зураг 4x3-ийн хэмжээтэй 2 хувь.

2.9. Ажлын алба сонгон шалгаруулалтад оролцогдын ирүүлсэн материалын бүрдлийг хянаж, хөрөнгө оруулалтын мэргэжлийн хороо, төрийн бус байгууллага, даатгуулагчийн төлөөлөл тус бүрээр шаардлага хангасан оролцогдын жагсаалтыг гаргаж, Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

2.10. Үндэсний зөвлөл нэр дэвшигчийн сонсгол хийж, оролцогсдоос нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөн арвижуулах үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр ажиллах хүсэл сонирхол, чадвар, туршлага, олон нийтийн эрх ашгийг илэрхийлэх чадварыг шалгуур болгож, төрийн бус байгууллага, хөрөнгө оруулалтын мэргэжлийн хороо, даатгуулагчийн төлөөлөл 5 хүнийг сонгож, энэ дүрмийн 2.1.1-т заасан төрийн байгууллагын төлөөлөл 2 хүний хамт Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилно.

2.11. Хяналтын зөвлөлийн гишүүнийг 3 жилийн хугацаатай томилох бөгөөд нэг удаа улируулан томилж болно.

2.12. Хяналтын зөвлөл анхдугаар хуралдаанаараа гишүүдийн олонхын саналааар даргыг сонгоно.

2.13. Хяналтын зөвлөлийн гишүүнийг дараах үндэслэлээр чөлөөлнө:

2.13.1. биеийн эрүүл мэндийн шалтгаан болон өөрийн санаачилгаар чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

2.13.2. нэр дэвшсэн байгууллагаа төлөөлөхгүй болсон;

2.13.3. гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

2.13.4. зөвлөлийн үйл ажиллагаанд хүндэтгэх шалтгаангүйгээр 3 ба түүнээс дээш удаа оролцоогүй;

2.13.5. хуульд заасан бусад үндэслэл.



Гурав. Хяналтын зөвлөлийн чиг үүрэг

3.1.Хяналтын зөвлөл нь энэ дүрэмд заасан үйл ажиллагааны жилийн ажлын төлөвлөгөөг тухайн жилийн 1 дүгээр сарын 20-ний дотор Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна.

3.2.Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг ажлын баг томилон, удирдамж гарган гүйцэтгэнэ.

3.3.Хяналтын зөвлөл нь олон нийтийг төлөөлөн хараат бусаар дараах чиг үүргийг хэрэгжүүлж, хөндлөнгийн хяналт тавьж ажиллана:

3.3.1.Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулах журмын хэрэгжилтэд хяналт тавих;

3.3.2.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулж байгаа үйл ажиллагаатай танилцах, үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.3.2.1.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн Газрын үнэт цаас худалдан авах үйл ажиллагаа;

3.3.2.2.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Монголбанкны үнэт цаас худалдан авах үйл ажиллагаа;

3.3.2.3.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг Төрийн сангийн нэгдсэн дансанд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах үйл ажиллагаа;

3.3.2.4.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг банкны системийн нөлөө бүхий банканд хадгаламж болон харилцах дансанд хадгалуулах хэлбэрээр байршуулах үйл ажиллагаа.

3.3.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хараат бусаар, бие даан, аливаа нөлөөнд автахгүй, хууль дээдлэн, шударга ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих;

3.3.4.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулж байгаа үйл ажиллагааны нөхцөл байдал, хууль тогтоомжийн хэрэгжилт болон нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хараат бус, бие даасан байдлыг үнэлэх зорилгоор судалгаа хийх, судалгаанд шаардагдах мэдээллийг холбогдох албан тушаалтнаас гаргуулан авах;

3.3.5.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулж байгаа үйл ажиллагааны ил тод байдлыг судлах, үнэлэх;



3.3.6. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад өгсөн зөвлөмжийнхөө хүрээнд авсан арга хэмжээний биелэлтийн талаарх мэдээлэл, тайлбарыг гаргуулан авах;

3.3.7. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулж байгаа үйл ажиллагаанд оролцогсдоос нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн бүртгэл болон шийдвэрлэлтэд хяналт тавих;

3.3.8. Хяналтын зөвлөлд ирсэн өргөдөл, гомдол, хүсэлт, албан бичгийг хүлээн авч, эрх хэмжээнийхээ хүрээнд хариу өгөх, шилжүүлэх;

3.3.9. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулж, өсгөн арвижуулах үйл ажиллагааны үр дүн хангалтгүй, хууль зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал үүссэн байна гэж үзвэл түүний шалтгаан, нөхцөлийг илрүүлж, арилгах, таслан зогсоох талаар эрх бүхий байгууллагад хандах.

3.4. Хяналтын зөвлөл нь нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулж байгаа нөхцөл байдал, үр дүн, хууль тогтоомжийн хэрэгжилт зэрэг асуудлаар ажлын албыг мэдээллээр хангаж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад зөвлөмж өгнө.

Дөрөв. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр

4.1. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан байна.


4.2. Хяналтын зөвлөл нь улиралд нэгээс доoshгүй удаа гишүүдийн гуравны хоёроос доoshгүй ирцтэйгээр хуралдана. Шаардлагатай тохиолдолд дарга, гишүүдийн олонхын санаалаар ээлжит бус хуралдаан зарлан хуралдуулж болно.

4.3. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Хяналтын зөвлөлийн дарга, гишүүд санал болгож, хэлэлцэх эсэхийг хуралдаанаар шийдвэрлэнэ.

4.4. Хяналтын зөвлөлийн хуралдаанаас зөвлөмж, удирдамж гарах бөгөөд дарга, хуралдаанд оролцсон гишүүд гарын үсэг зурна.

4.5. Хяналтын зөвлөл санал дүгнэлт гаргах, судалгаа, үнэлгээ, хяналтын ажлаа зөвхөн ажлын өрөөндөө явуулах бөгөөд шаардлагатай мэдээллээ нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гаргуулан авч байгаа бол хүлээн авсан болон хүлээлгэн өгсөн жагсаалт үйлдэнэ.

4.6. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гаргуулан авсан мэдээллийг зөвхөн албаны хэрэгцээнд ашиглах бөгөөд түүнийг хуулбарлах, гадагш авч гарах, хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр тараахыг хориглоно.



4.7. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын архивд хадгалагдаж байгаа мэдээлэлтэй танилцахдаа тус байгууллагын архивын үйл ажиллагааны журмыг мөрдөнө.

4.8. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд тавигдсан мэдээлэл, хагас бүтэн жилийн тайлан, сар, улирлын мэдээ болон бусад нээлттэй мэдээ, мэдээлэлд мониторинг, дүн шинжилгээ хийнэ.

4.9. Зөвлөл нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ажлын багийг томилон ажиллуулж болно. Зөвлөлийн хуралдаанаас хяналт үнэлгээ, судалгаа мониторинг хийх ажлын баг, багийн ахлагчийг томилж, удирдамж өгнө.

4.10. Хяналтын зөвлөл ажлаа Үндэсний зөвлөлд жил бүр тайлагнана. Хяналтын зөвлөл шаардлагатай гэж үзсэн асуудлаар тухай бүрд нь ажлын албаны даргад мэдээлж болно.

Тав. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүний эрх, үүрэг

5.1. Хяналтын зөвлөлийн дарга дараах эрхтэй:

5.1.1. Хяналтын зөвлөлийг төлөөлж нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бусад байгууллага, иргэдтэй харилцах;

5.1.2. Хяналтын зөвлөлийн хуралдааны товыг зарлан зохион байгуулж, удирдах;

5.1.3. Хяналтын зөвлөлийн ажлыг төлөвлөн зохион байгуулж, удирдах;

5.1.4. Хяналтын зөвлөлийн даргын эзгүйд түр орлох гишүүнийг томилох.

5.2. Хяналтын зөвлөлийн гишүүн дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.2.1. Хяналтын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар өөрийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх;

5.2.2. Энэхүү дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх талаар санал, санаачилга гаргах;

5.2.3. Хяналтын зөвлөлийн хуралдаанд заавал оролцох;

5.2.4. Хуулийн дагуу нууцад хамаарах мэдээлэлтэй эрх, үүргийн дагуу анилцсан бол холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

Зургаа. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
ажлын албаны чиг үүрэг

6.1. Ажлын алба Хяналтын зөвлөлийг удирдлага, чиг үүргээр хангаж ажиллана.

6.2. Хяналтын зөвлөл үйл ажиллагааныхаа жилийн тайлан, энэ дүрэмд заасан мэдээлэл, зөвлөмжийг тухай бүрд нь ажлын албанд ирүүлнэ.



6.3.Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг төлөвлөж жил бүрийн ажлын албаны төсөвт тусгаж, үйл ажиллагааг нь санхүүжүүлнэ.

6.4.Гишүүдэд ажлын оролцоог нь харгалзан улирал бүр урамшуулалт олгоно.

6.5.Гишүүдэд олгох урамшууллын хэмжээг ажлын албаны саналыг үндэслэн Үндэсний зөвлөл тогтоон.

6.6.Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах, хуралдааны зар түгээх, хуралдааны тэмдэглэл хөтлөх, хуралдаанаас гарсан шийдвэрийг албажуулж холбогдох газруудад хүргэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий ажилтныг ажиллуулна.

Долоо. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

7.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зөвлөлийг хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх талаар дараах чиглэлээр хамтарч ажиллана:

7.1.1.Энэ дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах;

7.1.2.Хяналтын зөвлөлийн байнгын ажлын өрөө, техник хэрэгслээр хангах, шаардлагатай үед нь хуралдааны танхимыг гаргаж өгөх;

7.1.3.Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгах;

7.1.4.Хяналтын зөвлөлд хандан Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга-/ийн 13 дугаар зүйд заасан үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх;

7.1.5.Хуульд өөрөөр заагаагүй бол зөвлөлийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;

7.1.6.Хяналтын зөвлөлийн хуралдаанд зөвлөлөөс гаргасан хүсэлтийн дагуу албан тушаалтан, ажилтнаа оролцуулах, мэдээ, мэдээлэл, тайлбар өгөх, хуралдаанаар хэлэлцэж байгаа тухайн асуудлаар саналаа хэлэх;

7.2.Хяналтын зөвлөлтэй хамтран ажиллах үүргийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, түүний эзгүйд Санхүү бүртгэлийн нэгжийн дарга хариуцна.

Найм. Хариуцлага

8.1.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.